



ДОРНОД АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН
ГАЗАР

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2026

МОНГОЛ ХЭЛ Онлайн сорил-3

2 сарын 14 14.00-15.20

Толгод

Үдшийн цагт тэнгэр толгодод сарны туяаг шившин оруулна. Гараг оддын аялгуу толгодоос эгшиглэн, нөмөрт нь хоргодом толгод эртний сайхан нөхөд мэт дотно. Энэ бяцхан толгод хэзээ нэгэн цагт уулс болно доо гэж бодном. Толгод хүүхэд адил өсөж, толгод хүүхэд адил олширч, үдшийн цагаан гэгээнд хөөцөлдөн эрхлэлдэхийг ажигуй энэ яваа насны учир утга, амьдрахуйн хүслэн тодорно. Тэнгэрээс ах настай уулсын эрх бяцхан ач нар болох энэ толгод салхитай, өвс ногоотой нөхөрлөж, одод дурлана.

Намрын үдэш олон бор толгодын дунд даарсан янзага надад бяцхан дүүг минь санагдуулна. Алгаа тоссоор дөхөхөд айсан нүд нь гэм зэмгүйн бэлгэдэл тэр жаахан амьтан холдосхийнэ. Толгод, янзага хоёр ихэр юм шиг санагдана. Хорин жилийн өмнөх ертөнц нүдний өмнө тодорч, эмээ минь толгодын оройд үлгэр шивнэн суух шиг...

Толгод, өвс ногоо, янзага, эмээ, салхи, бид зургаа нэгэн үлгэр болж, сарны туяанд олон толгод амилан, олон цагаан ботго гунганах шиг...

Үлгэр, үнэн хоёр сүлэрч, санаа бодол дээд цэгтээ хүртэл ариусаж, тархи толгойд минь одод бужигнан орж ирж, би өөрөө үгүй, хязгааргүй орон зай, тэнгэр, одод, толгодтой нэгдсэн мэт санагдана. Аажмаар энэ тансаг үлгэр минь тэнгэрт замхарч, бие жихүүцнэ. Бага насны үлгэрийн диваажингаас эргэж ирэхдээ жигтэйхэн эмзэглэж, “Толгодын тоогоор шүлэг бичих сэн” гэж адгана. Толгод бүхэн эх орноо хайрлах сэтгэлийн эрих юм. Сарны цагаан туяа шингэсэн толгоддоо би хорвоогийн жамаар очиж, толгодоос минь гараг оддын аялгуу эгшиглэх тоолон орчлонгийн хязгааргүйд би шингэнэ. Ийнхүү би шүлэглэнэм.

/О.Дашбалбар/

1.

Толгодыг эртний сайн нөхөдтэйгөө зүйрлэсний учир юу вэ?

- A. Бага насандаа тоглон наадаж өссөн учраас
- B. Хоргодох нөмөртэй байсан учраас
- C. Толгод амилан, олон цагаан ботго гунганах шиг санагдсан учраас
- D. Бяцхан дүүг минь санагдуулсан учраас
- E. Энэ яваа насных нь утга учир тодорсон учраас

2.

Эхийн дэвшүүлэн тавьсан асуудал буюу сэдвийг тодорхойлоорой.

- A. Хорвоогийн жам ёсны тухай
- B. Нөхөрлөлийн тухай
- C. Амьдралын утга учрын тухай
- D. Амьтны үр төлийг хайрлах тухай
- E. Эх орноо хайрлах тухай

3.

Эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.

- A. Үлгэр, үнэн хоёр сүлэрч, санаа бодол дээд цэгтээ хүртэл ариусна.
- B. Энэ бяцхан толгод хэзээ нэгэн цагт уулс болно доо.
- C. Орчлонгийн хязгааргүйд би шингэнэ.
- D. Толгод бүхэн эх орноо хайрлах сэтгэлийн эрх юм.
- E. Аажмаар энэ тансаг үлгэр минь тэнгэрт замхарч, бие жихүүцнэ.

4.

Эхийн онцолсон хэсгийн хэв маягийг зөв тодорхойлсныг олоорой.

- A. Хэрэг явдлыг цагийн дарааллын дагуу өгүүлсэн тул хүүрнэмж
- B. Энэ яваа насныхаа утга учрыг олон талаар задлан тайлбарласан тул тайлбарламж
- C. Хэрэг явдлыг нэг цагт зэрэгцүүлэн зурагласан тул тоочимж
- D. Үйл явдлын шалтгаант холбоог зэрэгцүүлэн үзүүлсэн тул хүүрнэмж, тоочимж хосолсон хэв маяг
- E. Уул толгодоос амьд явахын шалтгаан нь тодорч буйн учир начрыг баталсан тул эргэцүүлэмж

5.

“Сарны цагаан туяа шингэсэн толгоддоо би хорвоогийн жамаар очиж, толгодоос минь гараг оддын аялгуу эгшиглэх тоолон, орчлонгийн хязгааргүйд би шингэнэ.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгтэй ойролцоо утгатай хэлцийг олоорой.

A. хорвоогийн шороо хөдөлгөх

B. тэнгэрт халих

C. тэнгэр нь хаях

D. зүрх нь үхэх

E. толгойгоо ганзагалах

6.

“Толгод хүүхэд адил өсөж, толгод хүүхэд адил олширно.”- өгүүлбэрийн утгын харьцааг тодорхойлоорой.

A. Төсөөт утга

B. Эсрэг утга

C. Зүйлчилсэн утга

D. Ойролцоо утга

E. Төсөөрхүү утга

7.

Цөм өгүүлбэрийг олоорой.

A. Үзэсгэлэнгийнхээ туйлд хүрнэ.

B. Алтан гургалдай донгодно.

C. Сайхан юм үзнэ.

D. Дутуу мэдэрнэ.

E. Тансаг үнэр шингэнэ.

8.

“Эмээ минь толгодын оройд үлгэр шивнэн суух шиг...” гэсэн өгүүлбэрт байгаа онцолсон үг ямар гишүүн болох вэ?

A. өгүүлэгдэхүүн

B. байц

C. өгүүлэхүүн

D. тусагдахуун

E. тодотгол

9.

“Алтан гургалдайн жиргэх дуун сая сэтгэлийн гүнд хүрнэ.”-өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.

- A. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
- B. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
- C. Угсарсан нийлмэл өгүүлбэр
- D. Энгийн өгүүлбэр
- E. Холимог нийлмэл өгүүлбэр

10.

Эхийн өгүүлбэрүүдээс тонгоргон хувиргасныг олоорой.

- A. Аялгуут бяцхан толгод бүхэн минь эх орноо хайрлах сэтгэлийн эрх юм.
- B. Намрын үдэш даарсан янзага надад бяцхан дүүг минь санагдуулна.
- C. Аажмаар энэ тансаг үлгэр минь тэнгэрт замхран, бие жихүүцнэ.
- D. Ихэр юм шиг санагдана, толгод янзага хоёр.
- E. Алгаа тоссоор дөхөхөд тэр жаахан амьтан холдосхийнэ.

11.

Дараах холбоо үгийг ажиглаад, үндсэн утгаараа байгаа үгийг олоорой.

- | | | |
|-----------------|-----------------|-------------|
| A. ханиад хүрэх | B. уур хүрэх | C. ам хүрэх |
| D. хорхой хүрэх | E. дургүй хүрэх | |

12.

“Үлгэр, үнэн хоёр сүлэрч, санаа бодол дээд цэгтээ хүртэл ариусна.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үйл үгийн утгыг олоорой.

- A. нийлэх
- B. сарних
- C. замхрах
- D. холилдох
- E. шингэх

13.

Төрөл биш утгатай үгийг олоорой.

А. жиргэр

В. жирэм

С. жирий-

D. жирсхий-

Е. жирэлз-

14.

“дотно” гэсэн утгад тохирох хэлцийг олоорой.

А. хуруу дарам

В. хашир хандгай

С. салхин дэвүүр

D. зүү орох зайгүй

Е. гарын аяар

15.

Дараах холбоо үгсийн зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг сонгоно уу.
хангай дэлхий, тансаг үнэр, өнө мөнх, ариун үйл,

А. эцэг өвгөд

В. гоёмсог өнгө

С. дууны утга

D. дутуу бүхэн

Е. сайхан юм

16.

“Аажмаар энэ тансаг үлгэр минь тэнгэрт замхарч, бие жихүүцнэ.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг тохирох үгээр солин найруулаарай.

А. Дараа

В. Хожим

С. Цаашид

D. Яваандаа

Е. Чухамдаа

17.

. “Ардын дууны утга сая тайлагдаж, мартагдахын их далайг туулж ирсэн увдис нь бишрэл төрүүлнэ.” гэсэн өгүүлбэр дэх онцолсон бүтээврийг солин найруулбал аль нь хамгийн тохиромжтой вэ?

A. -вал

B. -нгаа

C. -хлаар

D. -снаа

E. -н

18.

. “Толгодын тоогоор шүлэг бичих сэн” гэж адгана.” гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийн утгыг олоорой.

A. хүсэх

B. боломжийг батлах

C. дурсан дурдах

D. нотлон батлах

E. барагцаалах

19.

. Олон тооны дагавар зөв хэрэглэснийг олоорой.

A. мянга гаруй ажилчид

B. бөхчүүд барилдах

C. хүүхдүүдэд бэлэглэх

D. зарим асуудлууд

E. хэсэг хүүхдүүд

20.

. “эмзэглэ-” хэмээх үгийн зөв бичих дүрмийн тайлбарыг олоорой.

A. Эгшигт гийгүүлэгч аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.

B. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх –л дагавар залгахад эгшгийг хойно нь бичнэ.

C. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч ороход заавал эгшигтэй бичигдэнэ.

D. Эгшгээр төгссөн үгэнд үйл үг бүтээх -л дагавар залгахад шууд бичнэ.

E. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх –л дагавар залгахад эгшгийг өмнө нь бичнэ.

21.

Буруу бичсэн бүлэг үгийг олоорой.

- A. харагдснаас, маллаа, авчихаад
- B. харчхаад, эмээллэлээ, товчилвол
- C. хүргээнэ, моджино, олгочхоосой
- D. түлхэхээр, түүхчдийг, нөхцөлөөр
- E. өгүүлбэрийг, уулзалтанд, тооцуулашгүй

22.

Цэгийн оронд тохирохыг нь сонгоно уу.

Өгүүлбэрийн доторх тайлбар, тодорхойлолт, нэмэлт ажиглалт зэрэг үг, өгүүлбэрийг бичнэ.

- A. хашилтад
- B. давхар цэгээр зааглан
- C. таслалтай зураасаар зааглан
- D. зураасаар зааглан
- E. хаалтад

23.

Д.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг” шүлгийн дүрслэлээс уншаад, улиралтай нь зөв харгалзуулсныг олоорой.

- | | |
|---|----------|
| 1. Хангайн бороо гэнэт асгах нь сайхан
Харанхуйн дунд цахилгаан гялбах нь сайхан | a. өвөл |
| 2. Цайдам хоолой цайвалзаж цанхиртах сайхан
Цаад уулс гялс гялсхийн харагдах нь сайхан | b. хавар |
| 3. Ургамал цэцэг ургаж ногоорох нь сайхан
Утасны мод хөхөрч гандах нь сайхан | c. зун |
| 4. Наран шаргалтаж тоорогтох сайхан
Навчсын шар шуурга хаялах сайхан | d. намар |
- A. 1c, 2a, 3b, 4d
 - B. 1a, 2d, 3b, 4c
 - C. 1b, 2a, 3c, 4d
 - D. 1c, 2b, 3d, 4a
 - E. 1b, 2c, 3a, 4d

24.

“Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир” зохиолд дарааллаараа тохирох хэсгийг олоорой.

Санасан үгийг маань биш үү

Сайн муу хоёрыг маань биш үү

Доторх үгсийг маань биш үү

Доор дээр хоёрыг маань биш үү

A. мэдүүлдэг, илрүүлдэг, ялгадаг, гаргадаг

B. гаргадаг, ялгадаг, илрүүлдэг, мэдүүлдэг

C. илрүүлдэг, мэдүүлдэг, гаргадаг, ялгадаг

D. ялгадаг, гаргадаг, мэдүүлдэг, илрүүлдэг

E. мэдүүлдэг, илрүүлдэг, гаргадаг, ялгадаг

25.

“Солонгын долоон өнгө билээ

Идээний таван амттан билээ

Ижил нь үгүй үнэртэн билээ

Ид шидийн үзэсгэлэн билээ.” гэсэн нь ямар зохиолын дүрслэлт хэсэг вэ?

A. Дөрвөн цаг /Д.Нямсүрэн/

B. Сэгс цагаан богд /Д.Пүрэвдорж/

C. Дэлхий /Б.Явуухулан/

D. Монголын их амар амгалан /Ц.Бавуудорж/

E. Миний монгол /Р.Чойном/

26.

Монгол бичгийн эхийг уншаад, зөв хөрвүүлснийг олоорой.

A. Өөхтэй тарган биш боловч эцэнхий морь ч уналга.

Ураг элгэн биш боловч итгэлтэй нөхөр тустай.

B. Өгөхдөө тарган биш боловч эцэнхий морь ч уналга.

Ураг элгэн биш боловч итгэлтэй нөхөр тустай.

C. Өөхтэй тарган биш боловч эцэнхий морь ч уналга.

Уурга илхэн биш боловч итгэлтэй нөхөр тустай.

D. Өөхтэй тарган биш боловч эцэнгэр морь ч уналга.

Ураг элгэн биш ч итгэлт нөхөр тустай.

E. Өөхтэй тарган биш ч туранхай морьд ч уналга.

Ураг элгэн биш ч итгэлтэй нөхөр тустай.

ᠡᠭᠡᠬᠡᠲᠡᠢ ᠲᠠᠷᠭᠠᠨ ᠪᠢᠰᠢ ᠪᠣᠯᠣᠪᠴᠢ ᠡᠴᠡᠨᠬᠢᠢ ᠮᠣᠷᠢ ᠴᠢ ᠤᠨᠠᠯᠭᠠ.

ᠤᠷᠠᠭ ᠡᠯᠭᠡᠨ ᠪᠢᠰᠢ ᠪᠣᠯᠣᠪᠴᠢ ᠢᠲᠭᠡᠯᠲᠡᠢ ᠨᠥᠬᠥᠷ ᠲᠤᠰᠤᠢ.

ᠡᠭᠦᠬᠡᠳᠡᠭᠡ ᠲᠠᠷᠭᠠᠨ ᠪᠢᠰᠢ ᠪᠣᠯᠣᠪᠴᠢ ᠡᠴᠡᠨᠬᠢᠢ ᠮᠣᠷᠢ ᠴᠢ ᠤᠨᠠᠯᠭᠠ.

ᠤᠷᠠᠭ ᠡᠯᠭᠡᠨ ᠪᠢᠰᠢ ᠪᠣᠯᠣᠪᠴᠢ ᠢᠲᠭᠡᠯᠲᠡᠢ ᠨᠥᠬᠥᠷ ᠲᠤᠰᠤᠢ.

ᠡᠭᠡᠬᠡᠲᠡᠢ ᠲᠠᠷᠭᠠᠨ ᠪᠢᠰᠢ ᠪᠣᠯᠣᠪᠴᠢ ᠡᠴᠡᠨᠭᠡᠷ ᠮᠣᠷᠢ ᠴᠢ ᠤᠨᠠᠯᠭᠠ.

ᠤᠷᠠᠭ ᠡᠯᠭᠡᠨ ᠪᠢᠰᠢ ᠴᠢ ᠢᠲᠭᠡᠯᠲᠡᠢ ᠨᠥᠬᠥᠷ ᠲᠤᠰᠤᠢ.

27.

Тийн ялгалын нөхцөлийг буруу дагуулсан хэсгийг олоорой.

A.	B.	C.	D.	E.

E.

of interest

28.

Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

A.

B.

C.

D.

E.

E.

பெரியார்

29.

“-уул” бүтээвэр залгахад аль нь өвөрмөц бичигдэх вэ?

A.	B.	C.	D.	E.

E.

६

30.

Хатуу дэвсгэрээр төгссөн үгийг олоорой.

A.

B.

C.

D.

E.

E.

பெயர்

31.

. “Зан авир” гэсэн холбоо үгийн онцолсон үг аль нь вэ?

A.



B.



C.



D.



E.



32.

Буруу бичсэн үгийг олоорой.

A.




B.



C.



D.




E.




33.

. “бөө удган” гэсэн холбоо үгийн онцолсон үг аль нь вэ?


A.




B.




C.



D.



E.



34.

“уурхайчин” гэсэн үгийг монгол бичгээр зөв бичсэн хэсгийг олоорой

A.

ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

B.

ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

C.

ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

D.

ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

E.

ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

35.

35. Бүх үгийг зөв бичсэн хэсгийг олоорой.

A.

ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ
ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ
ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

B.

ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ
ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ
ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

C.

ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ
ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ
ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

D.

ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ
ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ
ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

E.

ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ
ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ
ᠤᠤᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

2.1.

. Хэлцийн утгыг тунгаан, цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.

- | | |
|--|-------------------------------------|
| а. Хөөрхий Гармаагийн удирдана гэж юу байх вэ.
..... гэдэгтэй ижил юм болно биз. | 1. Могойн цус тэнгэрт |
| в. гэдэг шүү дээ. Хор уршиг дагуулах хэрэг
гэдгийг нь би гадарласан нь зөв байж. | 2. Үхрийн сүүлэн дээр
хутга |
| с. Ээжийг одоо буц даа гэдэг юм уу. Ээж ч гэгчээр
чамайг орхиод явж чадахгүй, одоо дуусахын
хооронд гэнэ л дээ, мэдэж байна. | 3. Суусан газраасаа
шороо атгана |
| д. гэгчээр одоо чи сүржигнэж гүйгээд яах вэ дээ.
Бүх юм дууссан. | 4. Ниргэсэн хойно нь
хашхирах |
| е. Одоо би хөдөөний ажлаас айхаа нэгэнт больсон.
Энд хүрч ирээд хэчнээн их юм хийж болохыг
ойлгосон. гэгч л болсон доо. | 5. Мах барагдахад
богтос ахлах |

2.2.

. Аман зохиолын жишээг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|------------------------|--|
| а. бэлгэ дэмбэрлийн үг | 1. Жавартай тэнгэрийн хаяа нэг улаан
Жаргалтай хатны хацар нэг улаан
Жалганд ургасан сухай нэг улаан |
| в. мялаалгын үг | 2. Сааль нь арвин байг
Саальчин нь мөнх наслаг. |
| с. зүйр цэцэн үг | 3. Ган зуднаас хамгаалдаг
Галт хар үнэгтэй
Гайхам сайхан Алтай минь |
| д. магтаал | 4. Найлзуурыг засаж нуруу болгодог
Нялхыг өсгөж эр болгодог. |
| е. ертөнцийн гурав | 5. Урд хормой дээр нь унага даага
Хойд хормой дээр нь хонь хурга гишгэг. |

2.3.

2.3. Зөвийг нь олж сонгоорой.

		1	2	3
a	Эр үгэнд “-ы” бичих үг	дарш	баяр	будаг
b	Зөөлний тэмдэг “и” болох үг	тахь + чих	хумь + чих	хорь + чих
c	Ялгах эгшиггүй үг	тана	цутгалан	дүгнэлт
d	“-на” нөхцөлийг шууд залгах үг	бүрх + нэ	хуул + на	хөлд + нө
e	Эр үгэнд “-ий” бичих үг	тарга	сандаг	тараг

2.4.

2.4. Дүрс ялган бичих үгсийг тохирох утгатай нь харгалзуулаарай.

- | | |
|----|-------------------|
| a. | 1. эрж хайх |
| b. | 2. эрх мэдэл |
| c. | 3. сэмпингийн эрх |
| d. | 4. газар ухах |
| e. | 5. чангалж эрэх |

1	A	2
2	E	2
3	D	2
4	C	2
5	B	2
6	D	2
7	B	2
8	D	2
9	C	2
10	D	2
11	C	2
12	D	2
13	B	2
14	D	2
15	A	2
16	D	2
17	E	2
18	A	2

19	C	2
20	B	2
21	A	2
22	E	2
23	A	2
24	C	2
25	B	2
26	A	2
27	D	2
28	E	2
29	A	2
30	C	2
31	B	2
32	D	2
33	E	2
34	A	2
35	D	2

2.1	a	5	1
	b	1	1
	c	2	1
	d	4	1
	e	3	1
2.2	a	2	1
	b	5	1
	c	4	1
	d	3	1
	e	1	1
2.3	a	2	1
	b	1	1
	c	3	1
	d	2	1
	e	3	1
2.4	a	2	1
	b	3	1
	c	4	1
	d	5	1
	e	1	1